

# ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨМӨР ЗАМ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.03.30

Улаанбаатар хот

Нэг: Дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн

## **1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх зорилтын хүрээнд:**

Цагдаагийн ерөнхий газрын Төмөр зам дахь цагдаагийн газар нь 2017 оны эхний 5 сард Монгол улсын хууль тогтоомж, Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, албан даалгавар, үүрэг, чиглэлүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандаа удирдлага болгон Төмөр замын хэмжээнд гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2017 онд хийх ажлын төлөвлөгөөний саналыг хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагч, Архидан согтуурахтай тэмцэх ахлах байцаагч, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байцаагч нараас санал авч нэгтгэн 6 бүлэг 37 заалттай төлөвлөгөө боловсруулан Улаанбаатар төмөр замын гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга, Төмөр зам дахь цагдаагийн газрын дарга нараар батлуулан хэрэгжилтийг ханган гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд голлон анхаарч ажиллаж байна.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа А.Лхавгадоржоор ахлуулсан кирминологи баг 2017 оны 1 дүгээр улиралд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчилд дүн шинжилгээ хийж, гарсан гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, таслан зогсоох чиглэлээр эргүүл, шалгалт болон бусад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахаар ажилласан байна.

Төмөр замын хэмжээнд гарч буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Сурагчдын холбоо, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран ерөнхий боловсролын сургуулиуд болон иргэдэд Төмөр замын аюултай бүсийн дэглэм”, Шинээр батлагдан гарсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.

Үүнд: 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар татах хэсэг дээр нийт 350 ажилчдад Архины хор уршиг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар 1 цагийн сургалтыг тус бүр зохион байгуулсан. Нийт 22 удаа сургалт сурталчилгааны ажил зохион байгуулж 2436 төмөр замчид хамрагдаж 35 төрлийн 4519 ширхэг тараах материал, санамж сэрэмжлүүлэг тараан ажиллаа. Орос 3 дугаар сургуулийн 3-7 ангийн нийт 150 сурагчдад “ төмөр замын аюултай бүс” сэдэв сургалт зохион байгуулж, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төмөр зам дээр гарсан осол, зөрчлүүдийн талаар дүрс бичлэг үзүүлсэн байна.

Төмөр замчдын амгалан тайван амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Эрүүгийн цагдаагийн албаны хар тамхитай тэмцэх газрын ахлах төлөөлөгч, цагдаагийн ахмад Д.Пүрэвдэлгэр, төмөр зам дахь цагдаагийн газрын ахлах мөрдөн байцаагч Д.Түвшинтөр, эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн ахмад Э.Одбаяр, Ахлах байцаагч, цагдаагийн ахмад Д.Өнөртөгс нар нь “Хар тамхи мансууруулах бодис”-ын

хор нөлөө, ЭХТА-ийн 175 зүйлд заасан гэмт хэргийн талаар сургалт зохион байгуулж, байгууллагын удирдлагуудтай уулзан ярилцсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахаас сэргийлэх чиглэлээр СЭМҮТ-ийн их эмч Ж.Гантулга, Ахлах байцаагч а/х Д.Өнөртөгсийн хамт УБТЗ-ын Ган зам сонинд “Архидалт донтох өвчин, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх” талаар төмөр замчдад ярилцлага өгсөн.

СЭМҮТ-ийн эмч Г.Гантулгаар “Архины хүний биед учруулах хор уршиг” сэдвээр УБТЗ-ын Татах хэсгийн 300 ажилтанд сургалт зохион байгуулсан.

ТЗЦГ-ын “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээг 2017 оны 03 сарын 24-ны өдөр зохион байгуулагдсан арга хэмжээний үеэр тус газрын Саатуулах байрны алба хаагчид идэвхитэй оролцон иргэд, төмөр замчдад МУ-ын “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай” хуулийн шинэчилсэн найруулгын талаар иргэдэд хууль эрх зүйн мэдээлэл өгч, зөвлөгөө зөвлөмж тараан ажилласан. Охид, эмэгтэйчүүдийг архи согтуурахаас урьдчилан сэргийлэх талаар 1 улиралд саатуулагдсан 675 иргэнд эмч, цагдаа нар зөвлөмж өгч, ЭМЯ-ны Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвөөс гаргасан “Стрестэй үедээ согтууруулах ундаа бүү хэрэглээрэй”, “Бие махбодад нөлөөлөх архины хор уршиг”, -ын 50 ширхэг, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тархвар зүй шуурхай удирдлагын албаны эрдэм шинжилгээний ажилтан Л.Азжаргал, мэргэжилтэн А.Ононгоо нар ирж ажиллан “Архины хордлогоос сэргийлье”, “Метилийн спиртийн хордлого” –ын талаарх сэрэмжлүүлэг материал 100 ширхэг тус тус оролцогч иргэдэд өгч ажилласан байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн мэргэжилтэн Д.Самбуу “ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-иар 6 төрлийн 150 ширхэг гарын авлаг материал тараан, иргэдэд зөвлөгөө өгч хамтран ажилласан.

Төлөвлөгөөнд тусгагдсан дагуу 2016 онд Гэмт хэрэг, зөрчилгүй хамт олноо манлайлан ажилласан улаанбаатар төмөр замын 10 байгууллагын удирдлага, олон нийтийн эргүүлд идэвхитэй сайн ажилласан 4 офицер, 4 төмөр замчныг мөнгөн шагналаар шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан.

УБЗҮТБ болон зангилаа, өртөө зөрлөгүүдэд эргүүл, жижүүрийг хувиарийн дагуу тогтмол ажиллуулж, хяналт тавин ажиллаж байна. Мөн Орон нутгийн суудлын галт тэргэнд өдөр 14-16 цагдааг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллуулж байна. Орон нутгийн суудлын галт тэрэг болон УБЗҮТБ, шугам замын өртөө зангилаадын гэмт хэрэг, зөрчил, халдлагад өртөж болзошгүй эмзэг цэгүүдийн судалгааг хэв журмын болон хэсгийн байцаагч нараар гаргуулан шаардлагатай тохиолдолд нэмэгдэл эргүүл, жижүүрийг ажиллуулж хэвшсэн байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “ Сар шинэ”, “ Вокзал”, “Сэрэмжлүүлэг”, “Сургалт”, “Согтуу-1”, “Нээлттэй хаалганы өдөр-1”, Нээлттэй хаалганы өдөр-2-ыг Замын-Үүд зангилаа, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах 1 сарын аян зэрэг 7 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ аяныг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан.

## **2. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх зүйн орчныг шинэчилж, сургалтын нөлөөг дээшлүүлэх зорилтын хүрээнд:**

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Б/646 дугаар тушаалаар тус Цагдаагийн хэлтэс нь газар болсонтой холбогдуулан урд хойд чиглэлд 2 дэд хэсгийг байгуулан ахлах төлөөлөгчтэй боллоо. Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор 11 ажлын байрыг батлагдсан орон тоондоо багтаан шинээр бий болгов. Дархан, Сайншанд зангилаанд дэд хэсэг хариуцсан ахлах төлөөлөгч, эрүүгийн цагдаагийн тасагт 2 туслах төлөөлөгч, төлөвлөлт, зохион байгуулалтын тасагт 1 ахлах мэргэжилтэн, Замын-Үүд зангилаанд хэсгийн байцаагч 1 хэсгийн байцаагч, Сайншанд, Олон-овоо, Айраг, Мандал өртөөнүүдэд тус бүр 1 цагдаагийн алба хаагч ажиллуулахаар шийдвэрлэн тоог нэмэгдүүлэн ажилласан.

2017 оны албаны сургалтыг ЦЕГ-ын даргын 2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн Б/58 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын 2017 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”, Б/257 тоот тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын сургалтын хөтөлбөр 2016-2019”, Цагдаагийн байгууллагаас Эрх зүйн сургалт сурталт, сурталчилгааны чиглэлээр 2017 онд хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, Төмөр зам дахь цагдаагийн газрын даргын баталсан газрын 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн албаны сургалтын төлөвлөгөөг удирдлага болгон зохион байгууллаа.

Тус газрын танхимын сургалтыг дараахь чиглэлээр зохион байгуулсан бөгөөд үүнд:

- Мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтыг 14 удаа 28 цаг 1285 алба хаагч
- Алба хаагчийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг 8 удаа 16 цаг 653 алба хаагч
- Мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах сургалтыг 12 удаа 24 цаг 750 алба хаагч
- Бие бялдрын бэлтгэлжилтийн сургалтыг 24 удаа 48 цаг 158 алба хаагч нийт давхардсан тоогоор 1865 алба хаагч хамрагдсан байна.

Түүнчлэн ажлын байран дээрх танхимын сургалтад аудио бичлэг 6 удаа ашиглаж, сургалтын зохиомол орчинг 1 удаа бүрдүүлсэн бөгөөд сургагч багш болон тасгийн даргаас дээшхи албан тушаалтан 17 удаа сургалт орж 1382 алба хаагч хамрагджээ.

Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын талаарх ойлголт, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Цэнгэлбаяраар 2 цагийн сургалт оруулан, газрын офицеруудаар дээрх хуулийг бүлэг бүлгээр нь сургалт орох хуваарь гарган батлуулж 8 удаагийн 16 цагийн, мөн Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн болон хохирогчийн сэтгэл зүйн онцлог, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үзэл баримтлал, цагдаагийн байгууллагаас хийж гүйцэтгэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх багц сургалтыг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Цэнгэлбаяр, УБХЦГ-ын ГБХХЭГХУСХ-ийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад Э.Баярбаясгалан нартай хамтран сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Ц.Тогос 5 удаагийн 10 цагийн сургалт тус тус орсноос гадна алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг бататгах зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” болон “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгаар тус тус тест боловсруулан алба хаагчдаас авч, давтан сургалтыг 2 удаа зохион байгуулжээ.

Алба хаагчдын харилцаа, ёс зүйг дээшлүүлэх зорилготой сургалтын хүрээнд:

- ✓ “Сэтгэл зүйн аюулгүй байдал ба харилцах чадвар”

- ✓ “Харилцааны 3 алтан дүрэм” сэдвээр, “Өөртөө итгэлтэй байдал ба миний аз жаргалын тойрог” кейсээр сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Ц.Тогос
- ✓ Эерэг хандлага сэтгэлийн толь” сэдвээр Сэтгэл зүйн үндэсний төвийн сэтгэл зүйч н.Уянга,
- ✓ Өөрийн үнэлэмж ба стресс даван туулах чадвар” сэдвээр Сэтгэл зүйн үндэсний төвийн сэтгэл зүйч Б.Энхлэн
- ✓ Архины хэрэглээ, хор хөнөөл” сэдвээр СЭМҮТ-ийн их эмч Ж.Гантулга нар 6 удаагийн 12 цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан байна.

#### 2017 оны эхний 5 сарын байдлаар тус газрын алба хаагчдаас

- ✓ Хууль сахиулах их сургуулийн эчнээ ангид 7 алба хаагч,
- ✓ Хууль сахиулах их сургуулийн магистрын сургалтанд 1 алба хаагч хамрагдаж байгаа бөгөөд
- ✓ ЦЕГ-ын даргын Б/27 тоот тушаалын дагуу “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сэтгэл зүйчдийг чадавхижуулах нь” сэдэвт 5 хоногийн модуль сургалт 1 алба хаагч,
- ✓ ЦЕГ-ын дэд даргын 3/151 тоот албан бичгийн дагуу “Сургагч багш бэлтгэх, мэдлэг ур чадварыг нь дээшлүүлэх, дадлага олгох, сурган заах, арга зүйн” 2 хоногийн сургалтад тус газраас 6 алба хаагч хамрагдан сертификат авсан болно.
- ✓ ЦЕГ-ын МТХГ-ын даргын 11/88 тоот албан бичгийн дагуу Гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, мэдээллийн бүртгэлийн “ESC системийн улсын хэмжээнд нэврүүлэх” сургалт 1 алба хаагч,
- ✓ Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн сургалтад Цагдаагийн ерөнхий газарт тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа С.Баярбат, хүний нөөцийн мэргэжилтэн цагдаагийн ахлах дэслэгч Г.Баярцэцэг нар суун, газрын офицер алба хаагчдад мэдээлэл хийн
- ✓ ЦЕГ-ын 2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн Б/112 дугаар тушаалын дагуу “Хятад хэлний анхан шат”-ны суралтад 1 алба хаагч
- ✓ Цагдаагийн байгууллагын аж ахуйн ажилтан, нярав нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд 2 алба хаагч
- ✓ ЦЕГ-ын сургалтын нэгдсэн төвд “Түрэн гаргах бүлгийн сургалт”-анд 40 алба хаагч
- ✓ ЦЕГ-ын Сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулж буй давтан сургалтанд 2017 оны 4, 5- дугаар сард сургалтанд хамрагдах 13 алба хаагчийн нэрсийг хүргүүлэн хуваарийн дагуу 6 алба хаагч хамрагдан тус газрын хэмжээнд нийт 62 алба хаагч сургалтад хамрагдаж
- ✓ Тус газрын бичээч, цагдаагийн дэд ахлагч Ц.Жаргал Хүүхэд ба шийдэл эрдэм шинжилгээний хуралд оролцсон байна.

Мөн өдөр Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны б/58 тоот тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2017 оны сургалтын календарчилсан төлөвлөгөө”-ний дагуу Сургалтын нэгдсэн төвд сургагч багш, тус газрын сэтгэл зүйч цагдаагийн ахмад Ц.Тогос нь “Уур бухимдлаа зохицуулах нь”, “Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, архины хэрэглээ, түүний хор нөлөө”, “Стрессийг даван туулах арга зам, түүнээс урьдчилан сэргийлэх” сэдвүүдээр, Холбоо мэдээллийн ажилтан, цагдаагийн ахмад

3.Оюунбадрах “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд орчин үеийн техник, технологи ашиглах нь” сэдвээр тус тус сургалт оржээ.

Алба хаагчдын албан хэргийн хөтлөлтийг сайжруулах, монгол хэлний зөв бичгийн дүрмийг албан хэрэгцээнд ашиглах, алба хаагчдыг чадвахижуулах зорилгоор Нийслэлийн 28-р сургуулийн монгол хэлний багш С.Нинжээр “Монгол хэлний зөв бичгийн дүрэм”-ээр сургалт оруулуулсан байна.

Түүнчлэн ажлын байран дээрх танхимын сургалтад аудио бичлэг 3 удаа ашиглаж, сургалтын зохиомол орчинг 2 удаа бүрдүүлсэн бөгөөд сургагч багш болон тасгийн даргаас дээшхи албан тушаалтан 10 удаа сургалт орж 799 алба хаагч хамрагджээ.

Эрх зүйн сургалт сурталчилгааны дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- “Цагдаагийн албаны тухайн хууль”-ийн шинэлчилсэн найруулга, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга, “Авилгатай тэмцэх тухай хууль” болон ХАСХОМ мэдүүлэхэд анхаарах асуудал, “Мэдээллийн ил тод байдлын тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай хууль”, Гамшгийн тухай хууль”, Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-уудаар, “Олон улсын гэрээ”, “Төмөр замын гарам аюултай бүс, анхаарах асуудал” сэдвүүдээр тус тус танхимын сургалт зохион байгуулсан байна.
- Алба хаагчдад хүний эрхийг хангаж, албаны ёс зүйг сахиж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр: “Харилцааны соёлоо дээшлүүлж, сахилга ёс зүйн зөрчилгүй хамт олон болцгооё” аяны удирдамж, төлөвлөгөө, “Инээмсэглэн угтая” үйлчилгээнд ажиллах офицеруудын хуваарийг гарган газрын даргаар батлуулав. Дээрх аяны хүрээнд алба хаагчдаас аяныг дэмжсэн баталгааны дэвтэр аялуулж, алба хаагчдыг “Өөрийн үнэлэмж” сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулснаас гадна
- Цагдаагийн алб хаагчийн харилцаа, ёс зүйг дээшлүүлэх зорилгоор “Зөв харилцаанд суралцах нь”
- албаны тухай /шинэчилсэн найруулга/ -ыг иргэд, олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах чиглэлээр “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг УБЗҮТБ-ын арын талбайд зохион байгуулж, хуулийн үзэл баримтлалын мэдээллийн самбар хэвлүүлэн байршуулж
- Шинэчлэгдэн батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийг хэрэгжүүлэх, иргэд олон нийтэд зохион байгуулах ажлын чиглэлээр: хуульд орсон 10 гол өөрчлөлтөөр самбар хэвлүүлэн УБТЗ-ын харъяа 10 байгууллагад байршуулан сургалт зохион байгуулжээ.

### **3. Алба хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллах зорилтын хүрээнд:**

Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 6 бүлэг 19 зүйлтэй боловсруулан батлуулж ажилласнаар тус газрын алба хаагчдын харилцааны соёл , арга зүй, үйл ажиллагааны чиглэл болж, улмаар байгууллагын алба хаагчдын харилцааг хөгжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх ажлын ачаалал, стресс бухимдлаас болж үүсдэг таагүй харилцаанд өөрчлөлт орж, алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйд ахиц гаргасан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 4/321 тоотоор ирүүлсэн “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор газрын хэмжээнд сахилга хариуцлагыг дээшлүүлэх 6 зүйл 19 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн газрын чиг үүргийн онцлогт тохирсон, алба хаагчдын харилцааны соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт сургалтыг төрийн болон төрийн бус гадны байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан байна

Тус цагдаагийн газраас 2017 онд сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчдын зөрчлын байдалд үнэлэлт өгч, тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодохгүй, албан үүрэг гүйцэтгэсний төлөө бусдаас шан харамж авахгүй байх, ЦАХ-ын ёс зүйг чанд сахих, оршин суугаа газраасаа гарахдаа удирдах даргадаа мэдэгдэх, ядарсан болон өвчтэй үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх, ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундааны зүйл хэрэглэхгүй байх зэрэг 9 төрлийн баталгааг гаргуулан авч Тус газрын алба хаагчдын харилцааны соёлыг дээшлүүлэх, улмаар байгууллагын үйл ажиллагаа болон алба хаагчдын харилцааг хөгжүүлэх чиглэлээр анхаарч төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран сургалт зохион байгуулан ажилласан байна

Цагдаагийн ерөнхий газрын удирдлагаас удаа дараа ирж байгаа үүрэг ажлын чиглэлд алба хаагчийн харилцаа хандлага, сахилга хариуцлага өнөөгийн тавигдаж байгаа шаардлагад хүрэхгүй байгаа талаар дурдан үүнд удирдлагаас тавих хяналт сул ажлын шалгуур үзүүлэлтэнд сахилга ёс зүйг оруулан дүгнэхгүй байгаа талаар дутагдалтай хандсан байдаг. Энэ дагуу удирдлагаас алба хаагч нарын ажлыг дүгнэж байгаа ЦБҮАЖын код 111 –ийн хүрээнд гарсан ажлын мэдээнд сахилга ёс зүйн талаар ажлын үзүүлэлт нэмж оруулан, алба хаагчийг дэвшүүлэх, цол олгуулах, дээд газрын шагналд тодорхойлохдоо гол шалгуураа болгож ирлээ. Газрын сахилга, ёс зүйн зөвлөлийг 2 удаа хуралдуулж зөрчил гаргасан Чойр зангилаан дахь дэд хэсгийн төлөөлөгч, цагдаагийн хошууч П.Амгалансайхан, а/х О.Гомбосүрэн, а/а Д.Түвшинжаргал, С.Цоггэрэл, А.Энхбаяр, П.Хонгорзул, зохицуулагч цагдаа П.Отгонсүрэн, суудлын цагдаа /гэрээт/, цагдаагийн ахлах ахлагч Б.Бат-Од, Э.Идэр, З.Одбаяр, нарын зөрчилд хийсэн шалгалтын дүнг хэлэлцэн баталгаа бичүүлэн авч, хугацаатай ажлын чиглэл өгч, мэдээллийн цагаар нийт алба хаагчдад анхааруулж, энэ төрлийн зөрчил ажлын дутагдал гаргахгүй ажиллахыг үүрэг болгосон байна.

Алба хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, сахилга ёс зүйг дээшлүүлэхэд анхаарч, гаргасан гэмт хэрэг, сахилгын зөрчил бүрийн шалтгаан нөхцөлийг тогтоож сахилгын зөрчил гаргасан алба хаагч нараар мэдээллийн өдрүүдэд тодорхой сэдвээр алба хаагчдад сургалт оруулан ажиллаж байна. Ээлжинд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад ажлын хариуцлага сахилга баттай байж, Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээний стандартыг ханган, иргэдтэй зөв боловсон харилцан ажиллах талаар Зөвлөмж өгч, газрын болон тасгийн даргаас өгсөн үүрэг зааварчилгааг хэрэгжүүлэн ажилласан.

Дотоод хяналт шалгалт явуулах төлөвлөгөөний дагуу газрын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэж байгаад гэмт хэрэг зөрчилд холбогдсон алба хаагчдын судалгааг тухай бүр нь гаргаж дүн шинжилгээ хийж сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй ажиллах талаар 5 удаагийн сургалт зохион байгуулж тасгийн дарга, ахлах байцаагч нар нь газрын дотоод хяналт шалгалт хийн өдөр бүр ерөнхий эргүүлээр ажиллаж газрын алба хаагчдад зааварчилгаа өгч ажилласан байна.

**Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Цагдаагийн төв  
байгууллагын даргын болон аймаг, нийслэл, дүүргийн өөрөө удирдах  
байгууллага, Засаг даргын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл  
ажиллагааны үр дүн**

Цагдаагийн газрын 2016 оны үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөмж гаргах үүднээс газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар 2016 оны хэрэглэгчийн үнэлгээний тайлан, 2016 оны жилийн эцсийн эд хөрөнгийн болон бараа материалын тооллогын дүн, газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, байгууллагын хяналт, шинжилгээ үнэлгээний тайлан, 2016 оны гэмт хэрэг зөрчлийн танилцуулга, Шилэн дансны 2016 оны гүйцэтгэл, 2016 оны газрын аюулгүй байдал, эрдслийн тайлангуудыг хэлэлцүүлж, хариуцсан албан тушаалтан нарт ажлын чиглэл, зөвлөмжийн өгч ажилласан.

Тус газар нь Цагдаагийн ерөнхий газраас 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх 18-н ажил, өөрийн байгууллагын ажлын онцлогтой уялдуулан 39-н ажил, цагдаагийн байгууллагын стратегийн зорилтын хүрээнд 6 бүлэг, 57 заалттай ажлыг төлөвлөж Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулан 2017 оны 01 дүгээр улирлын төлөвлөгөөний биелэлт болон тайланг ЦЕГ-т хүргүүлэн ажилласан.

УБТЗ-ын 32 байгууллага, шугам замын 9 зангилаа, 2 өртөө нийт 43 аж ахуй нэгж байгууллагын дарга нартай 2017 оны 01-р сарын 25-аас 2018 оны 01 дүгээр сарын 10-ныг дуустал төмөр замын салбарт үйлдэгдэж буй гэмт хэргийг бууруулах, аж ахуй нэгж дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж буй ажлыг эрчимжүүлэх, төмөр замчдад шинээр батлагдан гарсан хууль эрх зүйн мэдлэгийг сурталчлах, мэдлэгийг дээшлүүлэх, иргэд, төмөр замчдын оролцоог сайжруулах чиглэлээр 6 бүлэг 33 заалт бүхий “Түншлэлийн гэрээ”-г хэрэгжүүлэн ажиллахаар байгууллага, аж ахуйн нэгжийг 42 офицерт хуваарилан өгч, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 128-ын дагуу тайлангаа тавьж хамтран ажиллаж байна. Гэрээний хүрээнд жилийн эцсээр Архи, тамхигүй байгууллага, гэмт хэрэг зөрчилгүй байгууллага, олон нийтийн эргүүлд идэвхитэй оролцсон байгууллагыг шалгаруулж гардуулж урамшуулан ажлыг тогтмол зохион байгуулж байна.

2017 оны 1 дүгээр улиралд газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг 2017.01.24-ны өдрийн 02 дугаар хурлаар хэлэлцэн 33 заалттайгаар баталлаа. Хэлэлцэх асуудлыг хариуцсан алба хаагчид төлөвлөгөөний дагуу зөвлөлд танилцуулан ажилласан. Цаг үеийн шинжтэй асуудлыг тухай бүр хэлэлцүүлэн ажиллаа. 2017 оны 01 дүгээр улирлын байдлаар 6 удаа хуралдан 30 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

**Үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх,  
мэдээллийг тайлагнах чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүн:**

2016 оны хяналт, шинжилгээ үнэлгээг ЦБҮАЖ-ын код 110-ын дагуу Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үр дүнгийн үнэлгээг гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэсэн 3-н чиглэлээр гарган хүргүүлж. 2016 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээгээр тус газар нь 3.9 оноогоор үнэлэгдсэн.

ЦЕГ-ын даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/36 дугаар тогтоол “Цагдаагийн байгууллагаас 2017 онд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж биелэлт үр дүн тооцох баримт бичгийн жагсаалт”-ын хүрээнд өөрийн байгууллагын ажлын онцлогтой уялдуулан 34-н заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

### **Шүүх прокурорын мэдэгдэл, энгийн магадлалын дагуу авсан арга хэмжээ, үр дүн**

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, хэрэг бүртгэх эрх бүхий алба хаагчдаас 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар Тээврийн прокурорын газраас Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа зөрчиж прокурорын шаардлага аваагүй болно.

#### **Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээлэл:**

Гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн талаар:

Тус цагдаагийн газар нь 2017 оны 03 сард иргэн, байгууллага, аж ахуй нэгжээс нийт 153 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасны 77 буюу 50,3 хувь нь гэмт хэргийн, 76 буюу 49,7 хувь нь захиргааны зөрчлийн шинжтэй дуудлага мэдээлэл байна.

Нийт хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй 77 гомдол, мэдээллийн 22 буюу 28,6 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, 44 буюу 57,1 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргаж 36 буюу 54,5 хувийг 5 хоногт, 30 буюу 45,5 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргийн шинжтэй дуудлага мэдээллийг төрлөөр нь авч үзвэл: Хүний амь нас хохирсон -5, Бусдын бие, махбодид гэмтэлд учруулсан-6, Бусдын эд хөрөнгө хулгайлсан-27, Залилан мэхэлсэн-3, Бусдын эд хөрөнгө булаах-1, Танхайрсан-5, Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг-5, Бусад-25 болно.

Зөрчлийн шинжтэй 76 гомдол мэдээллийн 64 буюу 84,2 хувийг шийтгэврээр, 1 буюу 1,3 хувийг дуудлага худал буюу батлагдаагүй үндэслэлээр шийдвэрлэж 62 буюу 95,4 хувийг 14 хоногт, 3 буюу 4,6 хувийг 15-28 хоногт тус тус шийдвэрлэсэн байна.

#### **Бүртгэгдсэн гэмт хэрэг:**

Тус цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт 2017 оны 03 сард 25 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3 хэргээр буюу 10,7 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн ангиллын өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 7 хэргээр буюу 31,8 хувиар буурсан, хүндэвтэр гэмт хэрэг 3 хэргээр буюу 66,7 хувиар, хүнд гэмт хэрэг 1 хэргээр буюу 100 хувиар өссөн байна.

#### **Захиргааны зөрчил:**

Нийт 4103 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үед 4615 байснаас 512 нэгжээр буюу 12,5 хувиар буурсан. Торгуулийн хуудсаар 2412 иргэнийг 12 сая 60 мянган төгрөгөөр, шийтгэврээр 82 хүнийг 4 сая 5 мянган төгрөгөөр, гадаадын 25 иргэнийг 125 мянган төгрөгийн торгуулийн хуудсаар тус тус торгосон байна.

Захиргааны зөрчлийн улмаас учирсан хохирол:



Захиргааны зөрчлийн улмаас иргэн, аж ахуй нэгж байгууллагад нийт 7 сая 387,2 мянган төгрөгний хохирол учирснаас 100 хувь төлүүлсэн байна. Энэ учирсан хохирол нөхөн төлүүлэлтүүдийг задалбал: Галт тэргийг иргэн гармын бус газруудад саатуулсан-5, Төмөр замын гарамтай холбоотой-23 нийт 28 зөрчлийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Торгуулийн хуудсаар арга хэмжээ авсан байдал:

Нийт 4027 зөрчилд бэлэн болон бэлэн бусаар торгуулийн арга хэмжээ авсан байна. Үүнд: Танхайрах -1519, Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх- 622, Бусдын эд хөрөнгийг бага хэмжээтэй ашиглан шамшигдуулах-1, Худалдаа үйлчилгээний журам зөрчих-199, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар -1615, Бусдаар-13 зөрчлүүд байна.

**Санхүү, нийгмийн асуудлын талаар хэрэгжүүлсэн ажил**

2017 оны 01 дугаар улиралд улсын төсвөөс 326,669,900 төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого буюу цагдаагийн алба хаагч гэрээгээр ажиллуулах гэрээний орлого, бусад орлого 321,906,016.82 төгрөг, нийт 648,575,916.852 төгрөгийг төвлөрүүлэн 611,020,873.50 төгрөг, үлдэгдэл 32,555,043.352 төгрөг байна.

Цалин хөлс нэмэгдэл урамшилд: Үндсэн цалин, нэмэгдэл цалинд 319,515,000 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх ҮИД, АЖ-а 10,422,900 төгрөг.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: 2,221,866 төгрөг, өөрөөр 6,586,771.05 төгрөг, 2,445,397.77 төгрөг.

Хангамж бараа материалын зардал: 225,500 төгрөг, 1,182,759.50 төгрөг, Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 447,901 төгрөг

Нормативт зардал: Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 145,265 төгрөг, Хоол, хүнсэнд 3,711,600 төгрөг

Дотоод албан томилолтын зардалд 703,000 төгрөг.

Харуул хамгаалалтын зардал: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсөнд /гэрээтийн албан хаагчдын цалин хөлс болон бусад зардалд/ 254,814,248 төгрөг тус тус зарцуулсан.

Цагаан сарын баяраар газрын 70 ахмадыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэхэд 1,485,000 төгрөгийг зарцуулсан.

**Гэрээт харуул хамгаалалтын зардал:**

2017 оны 1-дүгээр сарын 01-ны өдөр УБТЗ нийгэмлэгтэй байгуулсан гэрээний төсвөөр 95 офицер, цагдаа ажиллуулахаар 1,276,707,701 төгрөгийн гэрээг хийсэн. 2017 оны 01 дүгээр улиралын байдлаар 319,176,916.82 төгрөгийн санхүүжилт авсан.

**Торгууль, шийтгэвэр:**

2017 оны жилийн эхэнд 5000 төгрөгний 88 төгрөгний үнэтэй 1173 ширхэг торгуулийн хуудас, 110 төгрөгний үнэтэй 242 ш шийтгэвэрийн үлдэгдэлтэй байснаас 1-3 сард торгуулийн тасалбар 3000 ширхэгийг орлогод авч, 1699 ширхэг торгуулийн

хуудсаар 8,495,000 төгрөгийн орлого 23 ширхэг шийтгэвэр зарлага болгож 1,137,500 төгрөгийн нийт 9,632,500 төгрөгийн орлогыг ЦЕГ-ын торгууль шийтгэврийн дансанд төвлөрүүлж ажиллаа.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү хангамжийн газрын 2016-02-23-ны №8/241 тоот албан бичгийн дагуу гэнэтийн ослын даатгалд хамрагдах 190 алба хаагчийн нэрсийг 2017 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 31а/458 тоот албан бичгээр хүргүүлсэн.

2017 оны 1 дүгээр улиралд цаашид ашиглагдах боломжгүй, ашиглалтын хугацаа нь дууссан 6,842,130 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,875,032 төгрөгийн тавилга аж ахуйн эд хогшил, нийт 10,717,162 төгрөгийн үндсэн хөрөнгө, 19,381,617 төгрөгийн бараа материалыг актлуулахаар саналыг ЦЕГ-ын Санхүү аж ахуйн албанд 31а/445 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан болно.

Тус цагдаагийн газар нь Монгол Улсын Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийг цаг хугацаанд мэдээлж ажилласан.

### **Долоо: Бусад ажлын талаар:**

Төмөр зам дахь цагдаагийн газрын эрүү, эдийн засгийн төлөөлөгч, хэсгийн төлөөлөгч нар 2017 оны 1-р улиралд 35 холбогдогчтой 169 сая 110 мянган төгрөгний хохиролтой 30 гэмт хэрэг илрүүлэн ажилласан байна.

Бусад албанаас гэмт хэргийн шинжтэй 17 илтгэх хуудас хүлээн авч шалгаж ажилласан байна.

### **Эрэн сурвалжлах ажлын талаар:**

Тус цагдаагийн газраас 2017 оны 1-р улиралын байдлаар Цагдаагийн байгууллагын “Эрэн сурвалжлах ажлын “ASAP” санд тус хэлтсээс оргодол 1, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 1, эд зүйлс 4, нийт 6 эрэн сурвалжлах хүн, цогцос, эд зүйлсийн мэдээлэл бүртгэгдэж зарлагдсан ба үүнээс оргодол 1, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 1, эд зүйл 2, нийт 4 мэдээллийн эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

1. Тус газраас эрүүгийн тоот хэрэгт гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000016 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 33 настай Цэрэннамжил овогтой Мэндсайхан РД:/ИЦ83022315/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

2. Тус газраас эрүүгийн тоот хэрэгт оргодолоор “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000004 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 53 настай Гончиг овогтой Даваасүрэн РД:/ Н362022675 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

3. Тус газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000019 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

4. Тус газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000018 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн газар хэлтсээс Цагдаагийн байгууллагын “Эрэн сурвалжлах АСАП сан”-д бүртгэгдэж зарласан оргодол 2, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 2 гэрээсээ гараад сураггүй алга болсон 1 шүүхээс оргон зайлсан 2 хүнийг олж тогтоон нутаг дэвсгэрийн цагдаагийн хэлтсүүдэд хүлээлгэн өгч ажилласан байна. Үүнд:

1.СХД-ийн цагдаагийн 1-р хэлтсээс эрүүгийн 201526012399 тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 541205516000137 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 28 настай Нармандах овогтой Ганжигүүр РД:/ М089100717 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

2.БГД-ийн цагдаагийн 2-р хэлтсээс эрүүгийн 201626022780 тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 541205217000004 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 35 настай Баасанжав овогтой Батгэрэл РД:/ ЧИ82011975 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

3.Сэлэнгэ аймгийн цагдаагийн газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 541104516000068 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 17 настай Жаргалсайхан овогтой Наранцэцэг РД:/ ИИ00231503 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

4.СХД-ийн цагдаагийн 1-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 541105516000111 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 40 настай Даваадулам овогтой Тэгшбаяр РД:/ Ч377010930/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

5.ХУД-ийн цагдаагийн 2-р хэлтсээс эрүүгийн тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 542306017000003 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 39 настай Чимэдгочоо овогтой Зундуй-Ёндон РД:/ ЧИ78051875 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

6.ЧД-ийн цагдаагийн 2-р хэлтсээс эрүүгийн 201525030196 тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 541206215000051 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 17 настай Содномцэрэн овогтой Баярмаа РД:/ УУ74110900 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

7.СХД-ийн цагдаагийн 1-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 541105516000107 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 28 настай Содномцэрэн овогтой Баярмаа РД:/ УУ74110900 /-ыг тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож ажилласан байна.

#### **Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн сэтгэл зүйчийн зүгээс:**

1. Тус цагдаагийн газарт Төрийн тусгай албаны сонгон шалгаруулалтанд орохоор хүсэлт гаргаж судлагдсан **11** иргэн, тус цагдаагийн газарт орж ажиллах хүсэлт гаргасан **10** иргэний сэтгэл зүйн онцлогийг тодорхойлж, ярилцлага явуулан, дүгнэлтийг гарган хүний нөөцийн мэргэжилтэн цагдаагийн ахлах дэслэгч Г.Баярцэцэгт материалын хамт өгөв.
2. Тайлангийн хугацаанд **104** алба хаагчид сэтгэл зүйн тандалт ярилцлага явуулж, зөвлөгөө, **9** алба хаагчид гэр бүлийн болон сэтгэл зүйн зөвлөгөө, ЦБҮАЖ-ын код 944 -Дасан зохицох хөтөлбөрийн хүрээнд **13** алба хаагчтай сэтгэл зүйн ярилцлага хийн, сэтгэл зүйн 4 төрөлт тестийг авч боловсруулж, **84** алба хаагчид хөдөлмөр хамгааллын сандлаар 28,3 цагийн үйлчилгээ үзүүлж ажилласан байна.
3. Тус газрын 181 алба хаагчид хувийн хэргийн баяжилтыг сэтгэл зүйн зарт болон алба хаагч бүрийн сэтгэл зүйн тодорхойлолтыг хэвлэн хийснээс тэтгэвэрт гарсан, халагдсан 10 алба хаагчийн хувийн хэргийг хаан, 19 алба хаагчид шинээр нээжээ.

**Эрүүгийн цагдаагийн тасгийн  
Жижүүрийн шуурхай удирдлагын хэсгээс:**

ЦБҮАЖ-ны код 200.4.4. 202-т заасны дагуу албан байгууллага, иргэдээс 101 мэдээ мэдээлэл, дуудлага хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 30, захиргааны зөрчлийн шинжтэй 71 дуудлага хүлээн авч ажилласан. ЦБҮАЖ-ын код 201.5.6 заасны дагуу төвөөс сүлжээгээр гэмт хэргийн-2975, хүн болон эд зүйл эрэн сурвалжилсан-2546 зарлан мэдээлэл хүлээн авч, эргүүл постонд дамжуулан эрэн сурвалжлах ажиллагаа зохион байгуулж ажилласан.

### **Албадан эрүүлжүүлэх, архидан согтуурахаас сэргийлэх ажлын хүрээнд:**

Саатуулах байр нь 2017 оны 1 улиралд архидан согтуурч, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 652 эмэгтэйг хүлээн авч саатуулсанаас төлбөр төлөөгүй 32 эмэгтэй, саатуулсан 620 хүнээс 2618650 төгрөгний төлбөр гаргуулан санхүүгийн албанд тушааж төлбөр төлөлт 95%- тай, өмнөх оны үеийхтэй харьцуулахад 5 эмэгтэй буюу 0,7%-иар буурч төлбөр төлөлт 1,8%-р буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Нийт албадан саатуулагдсан иргэдийн албадан хүргэгдэж ирсэн шалтгааныг тодруулбал:

1. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан –556
2. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож, гэмт хэрэг зөрчилд холбогдсон - 24
3. Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон – 72

Хаанаас хүргэгдэн ирсэн шалтгааныг тодруулбал:

1. Гудамж, талбай олон нийтийн газраас-105
2. Гэр орон сууц- 397
3. байгууллага аж ахуйн нэгж- 44
4. үзвэр үйлчилгээний газраас-44
5. баар цэнгээний газраас- 78
6. зочид буудлаас-26 иргэд тус тус хүргэгдэн ирж саатуулагдсан байна.

Асран хамгаалагчид нь 14 иргэнийг хүлээлгэн өгсөн. Саатуулагдсан 291 иргэдийн талаархи мэдээлэлийг ЦЕГ-ын Захиргааны тоо бүртгэлийн санд оруулж, саатуулагдсан эмэгтэйчүүдийн мэдээлэлийг тулгаж, хяналт тавин ажилласан. Үүрэг гүйцэтгэж байгаа 8 цагдаагийн алба хаагчид саатуулах байранд саатуулагдах хугацаандаа ЦАХ-ийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй 160 иргэнийг ЗХТХ-ийн 30.2.1 зүйлээр 800000 төгрөгөөр торгож, төлбөрийг тухай бүрт нь төрийн санд тушааж санхүүд тооцоо нийлж мэдээллийн санд оруулсан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахаас сэргийлэх чиглэлээр УБТЗ-ын харьяа “Ган Зам” зочид буудал, ресторан, түрээсийн саун, Тасалбарын төвийн “VIP ROOW”-ЫН үйл ажиллагаанд хяналт тавьж метилийн спиртийн хордлогоос сэргийлэх, МУ-ын АСТТХ-ийн санамж хадуулан ажилласан.

ЦЕГ-ын ТЗЦГ-ын “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээг 2017 оны 03 сарын 24-ны өдөр зохион байгуулагдсан арга хэмжээний үеэр тус газрын Саатуулах байрны алба хаагчид идэвхитэй оролцон иргэд, төмөр замчдад МУ-ын “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, ”Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай” хуулийн шинэчилсэн найруулгын талаар иргэдэд хууль эрх зүйн мэдээлэл өгч, зөвлөгөө зөвлөмж тараан ажилласан.

Охид, эмэгтэйчүүдийг архи согтуурахаас урьдчилан сэргийлэх талаар ЭМЯ-ны Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвөөс гаргасан “Стрестэй үедээ согтууруулах ундаа бүү хэрэглээрэй”, “Бие махбодад нөлөөлөх архины хор уршиг 50 ширхэг , Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тархвар зүй шуурхай удирдлагын албаны эрдэм шинжилгээний ажилтан Л.Азжаргал, мэргэжилтэн А.Ононгоо нар ирж ажиллан “Архины хордлогоос сэргийлье”, “ Метилийн спиртийн хордлого” –ын талаарх сэрэмжлүүлэг материал 100 ширхэг тус тус оролцогч иргэдэд өгч ажилласан байна.

Монгол Эм импекс компанийн эмч төлөөлөгч Ц.Мишээл “Архины шалтгаант элэгний өвчлөл” түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, “Эрүүл мэндээ хайрлая” зэрэг эрүүл мэндийн зөвлөгөө 12 иргэнд өгч ажилласан.

Саатуулах байрны эмч цагдаагийн дэслэгч Ш.Мөнхжих 18 иргэний артерийн даралт үзэн, эрүүл мэндийн зөвлөгөө өгч ажиллалаа.

Ээлжинд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад ажлын хариуцлага сахилга баттай байж, Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээний стандартыг ханган , иргэдтэй зөв боловсон харилцан ажиллах талаар Зөвлөмж өгч, газрын болон тасгийн даргаас өгсөн үүрэг зааварчилгааг хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

### **Замын хөдөлгөөний осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр:**

2017 оны 1 дүгээр улиралд гудамж замд хуваарийн дагуу 2 офицер, 5 зохицуулагч цагдаа ажиллаж, нийт 494 зөрчил илрүүлж, зөрчил гаргасан 486 хүнийг 15,536,000 төгрөгийн бэлэн бус хэлбэрээр торгож, эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 3, согтуугаар автомашин жолоодсон 6-н зөрчил илрүүлэн БГД-ийн Замын цагдаагийн хэлтэст шилжүүлж, Хан-уул дүүргийн нутаг дэвсгэрээс хулгайд алдагдсан тээврийн хэрэгсэлийг олж тогтоон ХУД-ийн Цагдаагийн 1-р хэлтэст шилжүүлсэн.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу улсын дугаарын хязгаарлалтын хүрээнд хяналт шалгалт хийж 42 зөрчил илрүүлэн бэлэн бусаар зөрчил гаргасан 42 хүнийг 336,000 төгрөгөөр торгож ажил, амралтын өдрүүдэд хяналт тавьж ажилласан.

Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан гомдол мэдээлэл 7хүлээн авч шалган, шийтгэврээр 7 хүнийг 528,000 төгрөгөөр торгож хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэлээ. Төмөр замын гарам дээр 2017 оны 2-р сард зам тээврийн осол гараагүй байна.

“САР ШИНЭ” нэгдсэн арга хэмжээнг зохион явуулж үр дүнг тооцон иргэд жолооч нарт зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, төмөр замын гармаар аюулгүй нэвтрүүлэх зорилгоор 25 дугаар суваг телевиз, Ган зам сонин, FM-96.3 радио, Мэдээ MN сайт дээр 1 удаа тус тус мэдээ, сэрэмжлүүлэг хүргүүлсэн.

Улаанбаатар төмөр замын Тээвэр зуучийн төв, Замын 2 дугаар ангийн гармын жижүүрүүд, Авто баазын жолооч нар, Талх чихэр ХХК, Силкроүд ХХК-ний жолооч нарт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар 5 цагийн сургалт зохион байгуулж, сургалтанд 216 жолооч, инженер техникийн ажилтан хамрагдсан.

Улаанбаатар төмөр замын Зорчигч үйлчилгээний төв буудал орчмоос хөдөө орон нутагт зөвшөөрөлгүй зорчигч тээвэрлэсэн 1 жолоочийн бичиг баримтыг Авто тээврийн үндэсний төвд шилжүүлж, 4 жолоочид дахин энэ төрлийн зөрчил гаргахгүй байх талаар баталгаа гаргуулж ажилласан.

Замын цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран төмөр замын гарам дээр гарч байгаа зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар “Анхаар галт тэрэг” шторк хийлгэж, Улаанбаатар төмөр замын Зорчигч үйлчилгээний төв буудлын хажуугийн Лед дэлгэцээр иргэд жолооч нарт сурталчилж байна.

Төмөр замын гарам дээр осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар “АНХААР ЗОГС ГАЛТ ТЭРЭГНЭЭС БОЛГООМЖИЛ” зурагт санамж 400 ширхэгийг иргэд, жолооч нарт тарааж санамж сэрэмжлүүлэг өгч ажилласан.

Цагдаагийн газар нь хуулиар хүлээсэн үндсэн үүргээ биелүүлэн ажиллахын зэрэгцээ дараах 6 зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Алба хаагчдын сахилга, ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлж, байгууллагын соёлыг иргэд төмөр замчдад түгээн, хууль сурталчлан ажиллах
2. Гэмт хэрэг зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийн чанарт анхаарч, бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн илрүүлэлтийг өмнөх оны мөн үеэс ахиулах
3. Удирдах ажилтан бүр манлайлал, ажлын хариуцлага, хүнтэй харилцах чадвараа дээшлүүлэхэд анхаарах
4. Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг чанаржуулж, алба хаагч нарыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад эдийн засгийн баталгааг бүх талаар хангах
5. Төсвийн сахилга бат, төсөв хэмнэлтийг бүх шатанд хэрэгжүүлэх
6. Алба хаагч, байгууллагын аюулгүй байдлыг бүх талаар ханган, гэмт хэрэг зөрчилд холбогдох, хохирохоос сэргийлэн ажиллах.

ТӨМӨР ЗАМ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР